

## ГАРЧИГ

<i>НЭГ. 2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i> .....	3
1.1. <i>Төслийн ерөнхий мэдээлэл</i> .....	3
1.2. <i>Уурхайн ашиглалтын систем, ажиллах горим, техник тоног төхөөрөмж</i> .....	5
<i>ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	9
<i>ГУРАВ. УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	19
<i>ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	19
<i>ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	19
<i>ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	19
<i>ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	20
<i>НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	25
<i>ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ</i> .....	30
<i>АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	33
<i>АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....	33
<i>ДҮГНЭЛТ</i> .....	33

## ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга.....	3
Хүснэгт 2. MV-017195 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн солбицлын цэгүүд.....	3
Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим.....	6
Хүснэгт 4. Уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө.....	6
Хүснэгт 5. Төслийн үндсэн тоног төхөөрөмжүүд.....	6

## ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төслийн байршлын зураг .....	4
Зураг 2. Бутлах үйлдвэрийн технологийн схем.....	7
Зураг 3. Бутлах цехийн тоног төхөөрөмжийн холболтын схем .....	7
Зураг 4. Уурхай орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулж, машины зогсоол хэсгийг тохижуулсан байдал.....	10
Зураг 5. Ус ашиглах гэрээ.....	11
Зураг 6. Ус ашиглах гэрээ.....	12
Зураг 7. Ус ашиглуулах дүгнэлт .....	13
Зураг 8. Ус ашиглуулах дүгнэлт .....	14
Зураг 9. Ус ашиглуулах дүгнэлт .....	15
Зураг 10. Ус ашиглуулах дүгнэлт .....	16
Зураг 11. Ус ашиглах эрхийн бичиг.....	17
Зураг 12. Ус ашиглах эрхийн бичиг.....	18
Зураг 13. Дүйцүүлэн хамгаалах зардал шилжүүлсэн баримт.....	19
Зураг 14. Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ .....	20
Зураг 15. Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ .....	21
Зураг 16. Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ .....	22
Зураг 17. Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ .....	23
Зураг 18. Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ .....	24
Зураг 19. Хог хаягдлын цэг .....	25
Зураг 20. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ.....	26
Зураг 21. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ.....	27
Зураг 22. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ.....	28
Зураг 23. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ.....	29
Зураг 24. Агаарын чанар, дуу чимээний шинжилгээний хариу .....	30
Зураг 25. Хөрсний шинжилгээний хариу.....	31
Зураг 26. Усны шинжилгээний хариу.....	32

## НЭГ. 2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга



№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“БИ СИ ЭМ ЭМ” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Хан-Уул дүүрэг, 13-р хороо, өөрийн байр.
3	Төслийн нэр	“Үнэсгэний хөндий-1” нэртэй барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах
4	Хүчинтэй хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт	1. Аж ахуй улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 9019061095 Улсын регистрийн дугаар: 5315425 2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл: Дугаар: MV-017195
5	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайн солбицол	Газар зүйн солбицол: ТЗ: MV-00007 Талбай: 40.25 га 106° 34' 50.00" - 47° 49' 23.00" 106° 35' 09.00" - 47° 49' 23.00" 106° 35' 09.00" - 47° 49' 50.00" 106° 34' 50.00" - 47° 49' 50.00"
6	Ордын геологийн бодит (В) нөөц	Барилгын чулуу: 3 349.33 мян.м <sup>3</sup>
7	Ордын үйлдвэрлэлийн нөөц	Барилгын чулуу: 2 882.06 мян.м <sup>3</sup>
8	Жилийн хүчин чадал	Барилгын чулуу: 250.0 мян.м <sup>3</sup>
9	Ордын ашиглалтын хугацаа	12 жил
10	Анхны хөрөнгө оруулалт	20.98 сая.төг

**Төслийн байршил:** MV-017195 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Үнэсгэний хөндий-1” барилгын чулууны ордын талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт Улаанбаатар хотоос БУ 30 км, Шувуун фабрикаас ЗХ 8 км-т Сонгинохайрхан уулын баруун урд үзүүрийн намхан толгодлог хэсэгт байрлана.

Уг орд нь MV-017195 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайтай бөгөөд тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүдийн солбицлуудыг дараах хэсэгт харууллаа.

Хүснэгт 2. MV-017195 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн солбицлын цэгүүд

Д/д	Хойд өргөрөг	Зүүн уртраг
1	47° 49' 23.0"	106° 34' 50.0"
2	47° 49' 23.0"	106° 35' 09.0"
3	47° 49' 50.0"	106° 35' 09.0"
4	47° 49' 50.0"	106° 34' 50.0"



Зураг 1. Төслийн байршлын зураг

## **1.2. Уурхайн ашиглалтын систем, ажиллах горим, техник тоног төхөөрөмж**

### **1.2.1. Ашиглалтын систем, ажиллах горим**

#### **Үйлдвэрлэл явуулах үндсэн шийдэл**

Ордын нийт нөөцийг 3349.33 мян.м<sup>3</sup>-ээр тооцсон ба үүнээс үйлдвэрлэлийн нөөц нь 2882.06 мян.м<sup>3</sup> байна. Техник эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэхдээ захиалагч талын саналын дагуу олборлолтод 3.5 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай Komatsu PC600 маркийн экскаватор, HOWO 20 тн автосамосвалын хослол ашиглаж, мөн LiuGong 50 маркийн утгуурт ашиглан жилд 250.0 мян.м<sup>3</sup> дайргыг ил аргаар олборлохоор төслийг боловсрууллаа.

Уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангах, техник тоног төхөөрөмжийг засварлах, тэдгээрийг хадгалах, үйлчилгээ материал хангамжийг газар дээр нь зохион байгуулах үүднээс уурхайн дэргэд захиргаа аж ахуйн байгууламж барьж байгуулна.

Уурхайн бүрэлдэхүүнд дараахь объектууд орно. Үүнд:

#### *Үйлдвэрийн объектууд:*

- ✓ Дайргыг ангилан ялгах төхөөрөмж
- ✓ Сэлбэг хэрэгслийн агуулах
- ✓ Дизель станц,
- ✓ Бусад байгууламжууд г.м

#### *Туслах объектууд:*

- ✓ Захиргаа аж ахуйн байр, хоолны газар /нарядны өрөө/
- ✓ Ажилчдын байр
- ✓ Халуун усны байр
- ✓ Машин тоног төхөөрөмжийн түр гарааж /сарай/, засварын газар
- ✓ Харуул хамгаалалтын байр
- ✓ Бие засах газар
- ✓ Хамгаалалтын хашаа г.м

Уурхайн түр тосгон нь тусгай сонгосон талбайд байрлах ба объектууд 24 цагийн турш харуул хамгаалалтанд байна. Ажилчдын байр, халуун усны байр, захиргаа аж ахуйн байрыг тохижуулсан контейнер ашиглан бүрдүүлнэ.

### **1.2.2. Уурхайн ажиллах горим.**

Уурхайн олборлолт хөрс хуулалтын үйл ажиллагаа нь 05 сарын 01-ны өдрөөс 10 сарыг дуустал дулааны улиралд явагдах бөгөөд Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын саатал, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлийг тооцсон. Уурхай нь хөрс хуулалт, уурхайгаас дайргыг олборлох, зөөвөрлөх, ангилан ялгах зэрэг үндсэн үйл ажиллагаа нь өдөрт 2 ээлжээр, ээлжинд 8 цагаар ажиллана. Уурхай нь:

#### **УУРХАЙ НЬ:**

**ХӨРС ХУУЛАЛТ ► ӨРӨМДЛӨГ ТЭСЭЛГЭЭ ► ДАЙРГА ОЛБОРЛОЛТ ► ТЭЭВЭРЛЭЛТ ► ДАЙРГЫГ БУТЛАХ, АНГИЛАН ЯЛГАХ, ► БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД АЧИЖ НИЙЛҮҮЛЭХ** гэсэн технологийн үндсэн горимын дагуу ажиллана.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Хуанлийн хоног	хоног	180
2	Баяр ёслол	хоног	6
3	Бэлтгэл ажлын хоног	хоног	5
4	Уурхайн жилд цэвэр ажиллах хоног	хоног	169
5	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	16
6	Ээлжийн тоо	ш	2
7	Нийт ажиллах цаг	цаг	2704

Энд ажлын үргэлжлэх хугацаанд тохиолдох албан ёсны амралт, баяр ёслолын өдрүүдийг тооцон хөрс хуулалтын ажил, олборлолт, ангилан ялгах төхөөрөмжийн ажиллах хугацаа 169 өдөр гэж тооцоолсон болно.

1.2.3. Уурхайн хүчин чадал, календарь төлөвлөгөө

“Үнэсгэний хөндий-1” барилгын чулууны ордын В-1 блокоос эхэлж олборлохоор төлөвлөв. Уулын ажлыг явуулахдаа хөрс хуулалтын явцад хуулсан хөрсийг зам талбайн ажилд хэрэглэн процессуудын хоорондын уялдаа холбоог уян хатан байлгах боломжийг бий болгож байгаа юм. Ордын хөрсний зузаан 0.5 м, барилгын чулууны зузаан 31.5 м байгаа тул уурхайн доголын өндөр дунджаар 5 м орчим байхаар байна. Уурхайн хажуугийн тогтворжилтыг хангахын тулд уурхайн хажуугийн өнцгийг 65-70 градусаас ихгүй налуутай байгуулна.

Хүснэгт 4. Уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Ашиглалтын жил	Уулын цул		Нийт хөрс		Үндсэн хөрс	Шимт хөрс	Үйлдвэрлэлийн нөөц	
	мян.м <sup>3</sup>	мян.тн	мян.м <sup>3</sup>	мян.тн			мян.м <sup>3</sup>	мян.тн
1-р жил	314.69	805.24	64.69	155.24	63.76	0.93	250.00	650.00
2-р жил	314.69	805.24	64.69	155.24	63.76	0.93	250.00	650.00
3-р жил	314.69	805.24	64.69	155.24	63.76	0.93	250.00	650.00
4-р жил	314.69	805.24	64.69	155.24	63.76	0.93	250.00	650.00
5-р жил	314.69	805.24	64.69	155.24	63.76	0.93	250.00	650.00
6-12-р жил	2084.85	5330.06	452.80	1086.71	446.29	6.51	1632.06	4243.35
<b>Нийт</b>	<b>3658.28</b>	<b>9356.29</b>	<b>776.22</b>	<b>1862.93</b>	<b>765.06</b>	<b>11.16</b>	<b>2882.06</b>	<b>7493.35</b>

1.2.4. Төслийн тоног төхөөрөмж


Олборлолтонд 3.5 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай Komatsu PC600 маркийн экскаватор, HOWO 20 тн автосамосвалын хослол ашиглаж, мөн LiuGong 50 маркийн утгуурт ашиглан жилд 250.0 мян.м<sup>3</sup> дайргыг ил аргаар олборлохоор төслийг боловсрууллаа.

Хүснэгт 5. Төслийн үндсэн тоног төхөөрөмжүүд


№	Тоног төхөөрөмжүүд	Марк	Хэмжих нэгж	Тоо
1	Экскаватор	Komatsu	ш	2
2	Автосамосвал	HOWO	ш	4
3	Утгуурт ачигч	LIUGONG50	ш	1
4	Бульдозер /түрээс/	SD-16	ш	1
5.	Өрмийн машин	ATLAS COPCO AIR ROCK D65	ш	1
	<b>Нийт</b>			<b>9</b>

**Ангилан ялгах тоног төхөөрөмжийн технологийн схем**

Тус төсөлд тусгагдсан дайрга бутлуурын иж бүрэн тоног төхөөрөмж нь хацарт болон конусан бутлуур, туузан дамжуурга, доргиурт болон ангилагч шигшүүр, бункер зэргээс бүрдэнэ.



Зураг 2. Бутлах үйлдвэрийн технологийн схем



Зураг 3. Бутлах цехийн тоног төхөөрөмжийн холболтын схем

*Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөний биелэлт*

2022 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 250.0 мян.м<sup>3</sup> барилгын чулуу олборлон борлуулахаар төлөвлөсөн боловч 2022 оны 10-р сарын байдлаар 15.0 мян.м<sup>3</sup> барилгын чулуу олборлож, үйлдвэрт нийлүүлсэн байна.



## ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал
1	Уурхай орчимд тоосжилт үүсэх	Уурхайн ам орчимд болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.
2		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	ОХШХ-ийн дагуу хяналт шинжилгээг хийлгэсэн.
3	Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх	Ус ашиглах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах	Ус ашиглах дүгнэлт гаргуулсан.
4		Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх	
5		Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Усны шинжилгээ хийлгэсэн.
6	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах,	Шимт хөрсний овоолго үүсгэн хадгалсан.
		Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах	
		Шимт хөрсний үржил шимийг алдагдахаас хамгаалж, өндөрлөж овоолго үүсгэх болон дагтаршуулахгүй байх	
7	Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.
8	Элсэн чулуу олборлосноор газрын хэвлийд хоосон орон зай шинээр үүсгэнэ.	Уурхайн малталтууд болон олборлосон орон зайд бэхэлгээ, хамгаалалтын цул зэргийг үлдээж нуралт үүсэхээс сэргийлнэ	Уурхай орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.
9	Уурхайгаас олборлосон элсэн чулууг бутлах, ангилах зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрсний овоолго үүсгэн хадгалсан.
10	Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах	Уурхай орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.



*Зураг 4. Уурхай орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулж, машины зогсоол хэсгийг тохижуулсан байдал*

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын  
2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн  
А-367 дугаар тушаалын хавсралт



БАТЛАВ

“БИ СИ ЭМ ЭМ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

*В. Ганбаатар* В.ГАНБААТАР

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 07 сарын 25-ны өдөр

Дугаар 9/31

Улаанбаатар хот

### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1 дэх хэсэгт заасны дагуу Нийслэлийн Байгаль Орчны Газрын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 2022/16 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай” А/304 дугаар захирамжийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Алтангэрэл, ус ашиглагчийг төлөөлж нийслэлийн Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, Үнсгэний хөндий-1 газарт 9019061095 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 5315425 регистрийн дугаартай “Би Си Эм Эм” ХХК-ийн захирал В.Ганбаатар нар ус ашиглах талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатайгаар байгуулав.

### Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. **Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл, зориулалт:** Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулдаг. Унд ахуйн усан хангамж, гудамж талбайн тоосжилт дарах, зүлэг ногоо услахад усыг авч ашиглана.

### 2.2. Ашиглах усны хэмжээ

2.2.1. Унд ахуй 34 м<sup>3</sup>

2.2.2. Үйлдвэрлэл

2.2.3. Үйлчилгээ

2.3. **Усны чанар, найрлага:** “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018”-ын шаардлага хангаж байна.

2.4. **Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо метрээр/:** 45 метрийн гүнтэй, 1 л/с ундаргатай худагтай. Ундаргаар нь тооцож үзэхэд хоногт дунджаар 86,4 м<sup>3</sup> ус авч ашиглах боломжтой. Хоногт дунджаар 34 м<sup>3</sup> ус авч ашиглаж байна.

2.5. **Байршил:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 13 дүгээр хороо, Үнсгэний хөндий-1

**Солбилцол:** 47°49'3.08"N, 106°34'56"E

**Барилга байгууламж:** Гүний худгаас өөр усны барилга байгууламж байхгүй.

**Тоног төхөөрөмжийн нэр, марк, хүчин чадал:** Ажилчдын амрах, оффиссын нийт 4 байр, том оврын машин механизм зэргээс бүрдэнэ. 40 ажилчин албан хаагчтай. Жилийн 169 хоног ажиллана.

2.6. **Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага:** Унд ахуйгаас гарах хаягдал бохир усыг хөрсөнд шингээж байна.

2.7. **Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:** Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2022 онд “South valley” ХХК-аар хийлгэж БОАЖЯ-аар батлуулахаар хүргүүлсэн.

2.8. **Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур, насосны хүчин чадал, марк:** Худагт Атлас копко маркийн насосыг 90 м гүнд суулгасан, 25 мм голчтой, 201801070 загварын усны тоолуурыг худгийн гаргалгааны шугам дээр суурилуулсан. 11000-17000-17150-06000 дугаартай худгийн паспорттай. Тоолуурын заалт 00001 м<sup>3</sup>.

2.9. **Онцгой нөхцөл:**

Зураг 5. Ус ашиглах гэрээ

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А/230/127 дугаартай тушаалаар батлагдсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 3.18 дах заалтад заасны дагуу эрүүл ахуйн хориглолтын бүсийг байгуулан мөрдөж ажиллах.

- БОНБНУ-ний тайланд устай холбогдуулан өгөгдсөн зөвлөмжүүдийг биелүүлэх.

- Унд ахуйгаас гарсан ахуйн бохир усыг хөрсөнд хаяхдаа Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015 ётандартад нийцүүлэн хаях шаардлагатай.

2.10. **Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:** “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 302, “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай”, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн төлбөрийг төлнө.

**1м<sup>3</sup> усны нөөц ашигласны төлбөр 9440 төг/м<sup>3</sup>\*0.07\*15%/100%=99.12 төг**

Нийт төлбөр болох 68,739.72 / *жаран найман мянга долоон зуун гучин есөн мянган төгрөг далан хоёр мөнгө*/ төгрөгийг хугацаанд нь төлөх

**Гурав. Талуудын эрх, үүрэг**

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

**Дөрөв. Бусад**

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН


**Ус ашиглуулагчийг төлөөлж:**

Хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтсийн дарга



Ц.Алтангэрэл


Хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтсийн Хог хаягдлын менежмент, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн



Хаяг: ХУД-ийн 20 дугаар хороо, Иргэдэд үйлчлэх төв байр 7 давхар 705 тоот

**Ус ашиглагчийг төлөөлж:**

Захирал




В.Ганбаатар

Хаяг: Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, Үнсгэний хөндий-1  
Утас: 89062538, 99232436

#### ГЭРЭЭ ХЯНАСАН

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, АРХИВЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ч.БАЙГАЛЬ

Зураг 6. Ус ашиглах гэрээ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР**

Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж-7/1,  
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0011  
Утас: (976-11) 32 77 80, Факс: (976-11) 32 06 69  
Цахим хуудас: www.environment.ub.gov.mn

2022.05.15 № 03/854  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

"БИ СИ ЭМ ЭМ" ХХК-НЫ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
В.ГАНБААТАР ТАНАА

Танай байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу "Усны тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтыг үндэслэн ус ашиглуулах дүгнэлтийг гаргав.

Хувийг: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Татварын хэлтэст

Хавсралт 3 хуудастай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



М.НЯМБАЯР

1155000510

Зураг 7. Ус ашиглуулах дүгнэлт



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН УС АШИГЛУУЛАХ  
ДҮГНЭЛТ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 2022/16

Улаанбаатар хот

"БИ СИ ЭМ ЭМ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ В.ГАНБААТАР ТАНАА

1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллага, захиралын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар: "Би Си Эм Эм" ХХК-ны захирал В.Ганбаатар, Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо, үнсгэний хөндийн-1 Утас: 99232436, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9019061095, Регистрийн дугаар: 5315425.
2. Төслийн байршил /ХӨ;ЗУ/: Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо, Үнэгэний хөндийн-1, 47°49'3.08"N, 106°34'56.56"E
3. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт: Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулдаг. Унд ахуйн усан хангамж, гудамж талбайн тоосжилт дарах, цэцэрлэг, зүлэг ногоо услахад усыг авч ашиглана.
4. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/: 41 ажилтан алба хаагчтай. 169 хоног ажиллана.
5. Үйлдвэрлэх боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ: 10-20 мм, 5-10 мм, 5 мм гэсэн мөхлөгүүдтэй байна. Ил уурхайн барилгын чулууны олборлолт 7.3 жилийн хугацаанд явагдана. Ашиглалтын жилүүдэд 2096.97 мян.м<sup>3</sup> дайрга, 1235.79 мян.м<sup>3</sup> элс үйлдвэрлэнэ.
6. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ: /шоо.метрээр/: 45 м гүнтэй гүний худагас өдөрт 86.4 м<sup>3</sup> ус авч ашиглах боломжтой. Өдөрт дунджаар 34.0 м<sup>3</sup> ус ашигладаг.
7. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/: Гүний худагас өөр усны барилга байгууламж байхгүй.
8. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /Насосны хүчин чадал, марк/: Худагт Атлас копко загварын насосыг 90 м гүнд суурилуулсан. LXSG-25 мм голчтой 201801070 загварын усны тоолуурыг суурилуулсан. Тоолуурын заалт 00001 м<sup>3</sup>.
9. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр, эх үүсвэр/ Худагас нөөцийн сан луу нөөцийн сангаас унд ахуй, ногоон байгууламжийн усалгаа, үйлдвэрийн тоосжилтонд авч ашигладаг.
10. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин: Унд ахуйгаас гарах ахуйн бохир шингэнийг хөрсөнд шингээж байна.
11. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл: Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2022 онд "South valley" ХХК-иар хийлгэж БОНХЯ-аар батлуулсан.
12. Онцгой нөхцөл:

1155000490

Зураг 8. Ус ашиглуулах дүгнэлт

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаартай тушаалаар батлагдсан "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 3.18 дах заалтад заасны дагуу эрүүл ахуйн хориглолтын бүсийг байгуулан мөрдөж ажиллах.
- БОНБНУ-ний тайланд устай холбогдуулан өгөгдсөн зөвлөмжүүдийг биелүүлэх.
- Унд ахуйгаас гарсан ахуйн бохир усыг хөрсөнд хаяхдаа Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус.Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартад нийцүүлэн хаях шаардлагатай.

**13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:** "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай" Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12, 13, 14 дүгээр хавсралтаар:

1. 1 ажилтан алба хаагч өдөрт 30 л ус авч ашиглан гэж үзвэл 41 ажилтан алба хаагч 224 хоногт  $275.5 \text{ м}^3$
2. Уурхайн дотоод замын тоосжилтыг дарахад  $1 \text{ м}^2$  газарт 2 л ус ашигладаг бол 1.9 га дотоод замын тоосжилтод 110 удаа услана гэж үзвэл  $418 \text{ м}^3$

**Нийт:  $693.5 \text{ м}^3$**

**14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:** "Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 302, "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай", "Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн төлбөрийг тооцоход:

- $1 \text{ м}^3$  усны нөөц ашигласны төлбөр  $9440 \text{ төг/м}^3 * 0.07 * 15\% / 100\% = 99.12 \text{ төг}$ 
  - $9440 \text{ төг/м}^3$  – Экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;
  - 15% - Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ;
  - 0.07- Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр;
- $693.5 \text{ м}^3 * 99.12 \text{ төг} = 68,739.72 \text{ төг}$  /Жаран найман мянга долоон зуун гучин есөн төгрөг, далан хоёр мөнгө/


**15. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээний талаархи зөвлөмж:**

- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.8, 29.1-д заасны дагуу Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газартай 2022 оны ус ашиглах гэрээг  $00001 \text{ м}^3$  тоолуурын заалтаас эхлүүлэн тооцож хийх.
- 2022 оны усны нөөц ашигласны төлбөрийг Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн дансанд 2022 оны 12 дугаар сарын 25-ны дотор тоолуурын заалтаар тооцож төлөх.  $1 \text{ м}^3$  усны төлбөр 99.12 төг.
- Тоолуурын заалтын баталгаа алдагдсан, шугам хоолойноос салгасан тохиолдолд усны нөөц ашигласны төлбөрийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцсон ус ашиглуулах дүгнэлтээр ноогдуулахыг анхаарах.
- Гүний худгийн усанд 2022 оны 9 дүгээр сарын 15-ны дотор хими бактерлогийн шинжилгээ хийлгэх. /Хан-Уул дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтэст хандаж шинжилгээ хийлгэх./
- Жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан тухай оны ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж байх.

*Зураг 9. Ус ашиглуулах дүгнэлт*

- Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтад заасны дагуу бохир ус хаях зайлуулах дүгнэлтийг Туул голын сав газрын захиргаанаас авч, дүүргийн Засаг даргын Тамгын газартай бохир ус хаях зайлуулах гэрээ байгуулах.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хэмнэлттэй байдлаар ашиглах шаардлагын хүрээнд цайны газар, угаалгын өрөө, саун, шүршүүрт мэдрэгчтэй төхөөрөмж суурилуулж усыг хэмнэх.
- Байгууллагын хашаанд мод тарьж, зүлэгжүүлэх ажлыг зохион байгуулах.
- Усны нөөц ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Усны тухай хуулийн 33.1.10-т заасны дагуу хариуцлага тооцохыг

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.НЯМБАЯР

Зураг 10. Ус ашиглуулах дүгнэлт



Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын  
2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн  
А-157 тоот тушаалын 2 дугаар хавсралт



## УС АШИГЛАХ ЭРХИЙН БИЧИГ

Дугаар 2018/12

.....-ын  
*/Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба/*

гаргасан 2018 оны 06 -р сарын 20 -ны өдрийн 2018/12 ..... дугаартай ус ашиглуулах дүгнэлт,  
**Дүүргийн Засаг даргын** ..... -ын  
*/Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга/*

олгосон 2018 оны 12 -р сарын 24 -ны өдрийн ус ашиглах зөвшөөрөл,  
**Хан-Уул дүүргийн Засаг дарга** ..... -тай  
*/Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга, Ус хангагч байгууллага/*

2018 оны 12 -р сарын 24 -ны өдөр байгуулсан 2018/12 ..... дугаар бүхий ус  
ашиглах гэрээг үндэслэн ..... **Нийслэлийн** ..... аймаг, нийслэл,  
**Хан-Уул** ..... сум, дүүрэг ..... 13 дугаар ..... баг, хорооны  
*/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хаяг/*

нутагт байршилтай, улсын бүртгэлийн ..... 9019061095 ..... тоот гэрчилгээтэй,  
5315425 ..... регистрийн дугаартай ..... **Би Си Эм Эм ХХК** ..... -г  
*/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр/*

ус ашиглахад тавигдах шаардлагыг бүрэн хангасан гэж үзэж, ХУД-ийн 13 дугаар хороонд  
байршилтай усны нөөцөөс хоногт ..... 34 м3 ..... шоо метр усыг  
*/гадаргын ус, газрын доорхи ус/*

**Унд ахуйн** ..... зориулалтаар ашиглах ЭРХИЙН БИЧИГ-ийг гурван  
жилийн хугацаагаар олгов.

Эрхийн бичиг олгосон:  
**Хан-Уул дүүргийн Засаг дарга** ..... **Ж.Алдаржавхлан** .....  
аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Байгаль хамгаалагч  
*/байгууллага, албан тушаалтны нэр, газрын үсэг/*



2018 оны 12 -р сарын 24 -ны өдөр

Зураг 11. Ус ашиглах эрхийн бичиг

**СУНГАЛТ**

Сунгалт хийсэн шийдвэр	Он, сар, өдөр	Гарын үсэг, тамга

Тайлбар:

Ус ашиглах эрхийн бичгийг Улсын усны мэдээллийн санд бүртгэнэ.

Зураг 12. Ус ашиглах эрхийн бичиг

## ГУРАВ. УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны уулын ажлын төлөвлөгөөнд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно.

## ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд НБОГ-тай хамтран “Ногоон хэрэм” хөтөлбөрт оролцсон бөгөөд уг ажлын зардалд 1.0 сая төгрөгийг зарцуулсан болно.

ШИЛЖҮҮЛЭГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ		ХҮЛЭЭН АВАГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	
Банкны нэр:	ХасБанк	Банкны нэр:	Төрийн банк
Данс:	5001699529	Данс:	203040506070
Нэр:	БАТБЭХРЕМИКОН ХХК	Нэр:	Мөнххантайшир ХХК
Дүн:	1,000,000.00	Дүн:	1,000,000.00
Валют:	MNT	Валют:	MNT

**ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Гүйлгээний дугаар: 141ТВ01222173014

Гүйлгээний утга: Би Си Эм Эм ХХК рд5315425 нөхөн сэргээлтийн төлбөр

Гүйлгээний шимтгэл: 200.00MNT

Гүйлгээний хүсэлт илгээсэн: batbehremicon2

Гүйлгээ баталсан: batbehremicon1

Гүйлгээ хийсэн огноо: 2022-08-05

Энэхүү цахим гүйлгээний баримтыг засварлах, Мэдээлэл өөрчлөх болон аливаа хууль бус зорилгоор ашиглахыг хориглоно.

Зураг 13. Дүйцүүлэн хамгаалах зардал шилжүүлсэн баримт

## ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


2022 онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

## ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Би Си Эм Эм” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна.

## ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд уурхайд галын булан байрлуулсан бөгөөд өрөмдлөг тэсэлгээний ажлыг “Мастер бласт энерги” ХХК-аар гүйцэтгүүлж, тэсрэх материалын сав баглаа боодлыг сервис компанид хүлээлгэн өгч аюул осолгүй ажилласан болно.



Зураг 14. Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ

## “БИ СИ ЭМ ЭМ” ХХК




### Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Гэрээний хугацаа: Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 12 сар байна.
- 2.2 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж тэсэлгээний ажил гүйцэтгэж дууссанаар дуусгавар болох ба талуудын хүсэл зоригийн илэрхийллийг үндэслэн гэрээг сунгана.

### Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1 Захиалагч нь гэрээгээр дараах үүрэг хүлээнэ.
  - 3.1.1 Гэрээний хугацаанд тэсэлгээний ажил хийх өдрийн тов, ажлын хэмжээг тодорхой агуулсан төлөвлөгөөг тэсэлгээ хийх өдрөөс 14 хоногийн өмнө Гүйцэтгэгч талд хүргүүлсэн байх;
  - 3.1.2 Тэсэлгээний ажлын чанарын баталгаат хугацаа нь тэслэгдсэн уулын цулыг ухаж, ачиж дуусах хүртэл хугацаагаар тодорхойлогдоно. Уулын цулыг бүрэн авч дууссаны дараа талууд гэрээний 1.1-д заасан хэмжээнд хүрсэн эсэх талаар дахин хэмжилт хийж баталгаажуулна. Хэрэв тэсэлгээний ажлын чанарт ямар нэгэн асуудал гарсан тохиолдолд 2 тал газар нь танилцаж акт үйлдэн, Гүйцэтгэгч талд албан мэдэгдэл хүргүүлэх;
  - 3.1.3 Тэсэлгээний ажлын паспортыг хуульд заасны дагуу баталгаажуулах;
  - 3.1.4 Тэсэлгээний ажил хийх талбайг чөлөөлөх, цэвэрлэх, гүйцэтгэгчийг мөрөгцөг рүү орох эрхээр хангах;
  - 3.1.5 Гэрээнд заасан төлбөрийг журмын дагуу төлөх;
  - 3.1.6 Гүйцэтгэгчийн гэрээний үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлүүд болон бусад эрх зүйн асуудлуудыг шийдвэрлэхэд өөрийн зүгээс шалтгаалах бүхий л арга хэмжээг авах;
  - 3.1.7 Өрөмдлөг тэсэлгээний ажлын үр дүнг гэрээний 3.1.2-т заасны дагуу хүлээн авч баталгаажуулна;
  - 3.1.8 Тэсэлгээ, өрөмдлөгийн ажлын үед тэсэлгээний аюулгүйн бүсэд бусдыг нэвтрүүлэхгүй байх, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах.
  - 3.1.9 Тэсэлгээний аюултай бүсэд байршиж байгаа хүн хүч, техник тоног төхөөрөмжийг тэсэлгээ эхлэхээс 30 минутын өмнө тус бүсээс гаргаж аюулгүй байдлыг хангах тус тус үүрэгтэй.
- 3.2 Захиалагч нь гэрээгээр дараах эрх эдэлнэ.
  - 3.2.1 Эрх бүхий төлөөлөгч нь гал өгөхөөс бусад тохиолдолд хэдийд ч тэсэлгээний ажлын явцтай танилцах;
  - 3.2.2 Ажлын чанарын талаар гэрээний 3.1.2-т заасны дагуу уулын цул нь гэрээнд заасан хэмжээнд хүрээгүй тохиолдолд нэмэлт тэсэлгээ хийхийг шаардах эрхтэй.
  - 3.2.3 Захиалагч нь гүйцэтгэгч компани ажилчдыг байр болон хоолоор ажил гүйцэтгэх хугацаанд хангана. / 5 ажилчин 4-5 хоног/
  - 3.2.4 Өрмийн машины түлшийг уурхай дээр хангах ба гарсан зардлыг ажлын хөлснөөс хасаж тооцно.

Зураг 15. Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ



Зураг 16. Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ

## “БИ СИ ЭМ ЭМ” ХХК



талбайд хонуулсан тохиолдолд харуул хамгаалалтыг гүйцэтгэгч тал өөрсдөө хариуцна. /

- 4.2 Гүйцэтгэгч нь гэрээгээр дараах эрх эдэлнэ:
  - 4.2.1 Гүйцэтгэсэн ажлын хөлсийг гэрээнд заасан журмын дагуу авах;
  - 4.2.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг захиалагчаас шаардах эрхтэй.
  - 4.2.3 Байгалын давагдашгүй хүчин зүйл, эсхүл төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээс шалтгаалан тэсэлгээ хийх, тэсрэх материалын тээвэрлэлтийг саатуулсан гэх мэт шалтгаанаар гэрээний үүрэг зөрчигдөхөд хүрвэл гүйцэтгэгч тал гэрээний хугацаа хэтрүүлсэнд тооцохгүй.

### Тав. Тэсэлгээний ажлын гүйцэтгэл хүлээлгэн өгөх

- 5.2 Гүйцэтгэсэн ажлын хэмжээг уурхайн дарга болон гүйцэтгэгч тал шалган баталгаажуулж баримтжуулна. Уг баримт нь хүчин төгөлдөр санхүүгийн баримт болно.
- 5.3 Захиалагч нь зөрчил, гологдол зэрэг үүргийн гүйцэтгэлийн чанарын талаар шаардлага гэрээний 3.1.2.-т заасан хугацаанд гаргах эрхтэй.
- 5.4 Захиалагч гэрээнд зааснаас бусад үндэслэлээр ажил хүлээн авахаас татгалзах эрхгүй.
- 5.5 Тэсэлгээний ажлын өрөмдлөгийг 127мм-ээр гүйцэтгэх бөгөөд торлолыг тэслэгдэх хөрсний шинж чанараас хамааруулан тооцоолно.
- 5.6 Тэслэгдсэн уулын цулыг гэрээний 4.1.8-н дагуу хүлээн авсан бодит уртаашыг өрөмдлөгийн торлолын нийлбэрээр үржүүлж тооцно.
- 5.7 Тэсрэх бодисын хувийн зарцуулалтыг тухайн тэслэгдэх хөрсний шинж чанараас хамааруулан тооцоолох бөгөөд тэсрэх бодисын хувийн зарцуулалт нь 0.3-аас багагүй байна.
- 5.8 Уурхайн нөхцлөөс хамаарч устай цооногт эмульсийн тэсрэх бодис ашигласан тохиолдолд “АЖЛЫН ХӨЛС, ТӨЛБӨР ТӨЛӨХ ЖУРАМ”-ын 1.1-н дагуу төлбөрийг тооцож төлнө.

### Зургаа. Ажиллах нөхцөл

- 6.1 Талууд ажиллахдаа гэрээний агуулагд дурдсан асуудлаар бие биедээ өгсөн үнэлэлт, санал, хүсэлт, зөвлөмжийг анхааралдаа авна.
- 6.2 Талууд шаардлагатай арга хэмжээг авахуулах зорилтын үүднээс гүйцэтгэхэд саад болж буй бэрхшээлийн тухай бие биедээ нэн даруй мэдэгдэнэ.

### Долоо. Ажлын хөлс, төлбөр төлөх журам

- 7.1 Ажлын хөлсийн хэмжээ, төлбөр төлөх журмыг Хавсралт №1-р тодорхойлно.
- 7.2 Захиалагч нь ажлын хөлсийг гүйцэтгэгч талын нэхэмжлэлийг хүлээн авсан даруй 5 хоногт багтаан төлнө.
- 7.3 Тэсэлгээний ажил гүйцэтгэх хугацааг 2 тал тухай бүрт тохирох бөгөөд Гүйцэтгэгч нь тохиролцсон хугацаанд ажлыг хийж гүйцэтгээгүйн улмаас захиалагч талд гарсан хохиролыг гүйцэтгэгч тал төлбөрөөс хасч тооцуулна. Хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.01%-ийн алданги тооцно.

Зураг 17. Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ

## “БИ СИ ЭМ ЭМ” ХХК



### Найм. Маргаан шийдвэрлэх

- 8.1 Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан аливаа хоорондын маргаантай асуудлыг талууд хамтын хүчин чармайлтаар эвээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд нэг мөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол улсын шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 8.2 Гэрээний хариуцлага, хохирол нөхөн төлөх асуудлыг МУ-ын хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

### Ес. Бусад заалт

- 9.1 Энэ гэрээгээр зохицуулаагүй харилцааг Иргэний хуулийн холбогдох зүйл заалтаар зохицуулна.
- 9.2 Давагдашгүй болон гэнэтийн хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон эсхүл аль нэг талд хохирол учирсан тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 9.3 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох ба гэрээний талууд харилцан тохиролцон гэрээнд гагцхүү бичгээр нэмэлт өөрчлөлт оруулна. Нэмэлт өөрчлөлт болон баталгаажуулсан хавсралт нь гэрээний нэг адил хүчинтэй, гэрээний салшгүй хэсэг байна.
- 9.4 Гэрээг цуцлахдаа цуцлах санал гаргасан тал нөгөө талдаа 30-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.
- 9.5 Бүх санхүү, техник болон энэхүү гэрээтэй холбоотой бусад мэдээллийг нөгөө талын бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахгүй. Энэхүү заалтыг зөрчсөний улмаас бий болсон хохирол, алдагдлыг буруутай тал хариуцна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН	
<b>Захиалагч талыг төлөөлж:</b> В.Ганбаатар <i>В.Ганбаатар</i> Гарын үсэг, Тамга	<b>Гүйцэтгэгч талыг төлөөлж:</b> Б.Түмэндэлгэр <i>Б.Түмэндэлгэр</i> Гарын үсэг, Тамга
<b>Албан тушаал:</b> Гүйцэтгэх захирал	<b>Албан тушаал:</b> Ерөнхий захирал
<b>Хаяг:</b> ХУДүүрэг, 13-р хороо, Үнэгсэний хөндий-1 байрлах	<b>Хаяг:</b> Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 26-р хороо Сакура оффис 4 давхар 406 тоот.
<b>Утас:</b> 89052638	<b>Утас:</b> 99118525, 99102112
<b>Цахим хаяг:</b> BiSiEmEm2022@gmail.com	<b>Цахим хаяг:</b> ceo@masterblast.mn

Зураг 18. Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ



## НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд хог хаягдлыг түр хадгалах цэгийг ангилан ялгах боломжтой байдлаар тохижуулсан бөгөөд “Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ”-г “Хан-Уул дүүргийн тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-тай байгуулан хуваарийн дагуу тогтмол тээвэрлүүлсэн болно.



Зураг 19. Хог хаягдлын цэг

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ	БАТЛАВ ТОХИЖИЛТ Ц.ЭРДЭНЭБААТАР	БАТЛАВ БИ СИ ЭМ ЭМ ХХК ЗАХИРАЛ <i>Ганболд</i>	В.ГАНБААТАР
2022 оны 04 сарын 14 өдөр			Улаанбаатар хот

ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

Дугаар 14-13/22

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Нэг талаас 5673461 тоот регистрийн дугаартай Хан-Уул дүүргийн “Тохижилт үйлчилгээний Төв” ОНӨААТҮГ (цаашид Гүйцэтгэгч гэх), нөгөө талаас 5315425 тоот регистрийн дугаартай, Хан-Уул дүүргийн 13-р хорооны нутаг дэвсгэрт байрлах ЭЛС, ХАЙРГАНЫ ОРД чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг БИ СИ ЭМ ЭМ ХХК (цаашид Захиалагч гэх) нар доорхи нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээ нь 2022 оны 04 сарын 01 -ны өдрөөс 2023 оны 03 сарын 31-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.3 “Хог хаягдлын тухай” хуулийн хүрээнд ХУД-ийн нутаг дэвсгэрийн орон сууц, гэр хорооллын айл өрх, ААН байгууллага болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тээвэрлэх, мөн нийтийн эзэмшлийн зам талбайд үүссэн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.4 Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 09-р сарын 26-ны өдрийн 12/45 дугаар тогтоолоор Хог тээврийн үйлчилгээний хураамжид НӨАТ (нэмэгдсэн өртгийн албан татвар)-ыг тооцоогүй болно.
- 1.5 Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 04-р сарын 18-ны өдрийн А/29 тоот тогтоолын дагуу гэрээний үнийн дүнг хоёр тал харилцан тохиролцон тогтоосон болно.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 2.1 Гүйцэтгэгч нь захиалагчтай байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу ААН байгууллага, орон сууцны бункерийн хог хаягдлыг саадгүй ачиж тээвэрлэх үүрэгтэй.
- 2.2 Тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар нэмэгдэл хүч зохион байгуулан ачуулах арга хэмжээг авна.
- 2.3 Айл өрхөөс гарч буй ахуйн хогийг тогтмол цагт цуглуулах, мөн барилга барих, буулгах, засварлах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжийн хог хаягдлын төлбөрийг төлүүлсний дараа тээвэрлэнэ.
- 2.4 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх.
- 2.5 Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ үзүүлсний төлбөрийг ААН, байгууллага болон иргэд, захиалагч байгууллагуудаас шаардах эрхтэй.
- 2.6 Захиалагч тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулаагүй тохиолдолд хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.

002213

Зураг 20. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ

## 2.7 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

### Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1 Захиалагч тал “Хог хаягдлын тухай (шинэчилсэн найруулга)” хуулийг мөрдөж ажиллана.
- 3.2 Тухайн ААН, байгууллага, барилга байгууламжаас гарсан хог хаягдлыг зөвхөн тогтоосон хогийн цэг буюу бункерт хийж ачуулах үүрэгтэй.
- 3.3 Тухайн ААН, байгууллага өөрийн талбай (хашаа)-аас гадагш **50 метрийн** зай дахь талбайн цэвэрлэгээг хариуцах үүрэгтэй. Цас орж, мөс тогтсон мөн бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг байнга хийж гарах хог хаягдлыг тээвэрлүүлж байна.
- 3.4 Захиалагч тал нь гэрээний 3.2-д заагдсан үүргийг биелүүлээгүй улмаас аливаа ААНБ, иргэнд учирсан хохирлыг Захиалагч тал бүрэн хариуцна.
- 3.5 Хог хаягдлын төлбөрийг сар бүрийн 25-нд Хан-Уул Дүүргийн **Татварын Хэлтэс** болон **itax.mta.mn** сайтаас код авч тушаана.
- 3.6 ААН, байгууллагын барилга байгууламжид засвар хийсэнтэй холбогдон гарсан барилгын болон бусад хог хаягдлыг тухай бүрд нь дуудлага өгч буюу захиалгаар тээвэрлүүлэх үүрэг хүлээх бөгөөд хогны хэмжээнээс хамааран нэмэлт төлбөр төлж хариуцсан албан тушаалтантай хамтарч ажиллана.
- 3.7 Хог агуулах зориулалтын савыг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх бөгөөд хог ачихад саад учруулахгүй газар байрлуулж, машин чөлөөтэй орж гарах нөхцөлийг хангана.
- 3.8 Хогийн сав, бункерийн орчимд машин тэрэг тавиулсны улмаас хог ачих боломжгүй болж хог тээвэрлэх автомашин буцах, хугацаа алдсан тохиолдолд холбогдон гарах хариуцлагыг Захиалагч хүлээнэ.
- 3.9 Өөрийн эзэмшил, өмчлөлийн барилгаа барих, буулгах, засварлах тохиолдолд гарах хог хаягдлыг хаях талаар гүйцэтгэгч талтай урьдчилан гэрээ байгуулан зохих төлбөрийг төлнө.
- 3.10 Хог хаягдал гаргасны төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.
- 3.11 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх.
- 3.12 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах.
- 3.13 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага орчны газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийг хамарсан ажилд оролцох үүрэгтэй.
- 3.14 Гүйцэтгэгчээс ажил үүргээ тогтоосон хугацаанд гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 3.15 Дүүрэг болон бусад байгууллага, албан тушаалтнаас зарласан уралдаан, аянд идэвхитэй оролцож тодорхой үр дүн үзүүлсэн бол шагнал урамшуулал хүртэх эрхтэй.
- 3.16 Гүйцэтгэгч ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төлбөр төлөхгүй байх эрхтэй.
- 3.17 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг эдэлнэ.

### Дөрөв. Төлбөр тооцоо, үнэлгээ

- 4.1 Гэрээт хугацаанд **рейс захиалгаар** иргэн, ААНБ-ийн бункерийн хог, хаягдлыг ачиж тээвэрлэнэ.
- 4.2 Хог тээвэрлэсний төлбөр нь ХУД-ийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон тарифын дагуу харилцан адилгүй байх бөгөөд тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу сард ..... улиралд ..... жилд ..... төгрөг байна.

*Зураг 21. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ*

- 4.3 Тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу Орон сууц, ААН, хувь хүний захиалгаар хог тээвэрлэлт хийхэд гарах төлбөр:
- |                               |                        |                     |
|-------------------------------|------------------------|---------------------|
| 6-8 тн шахдаг автомашин       | - Ахуйн хог хаягдал    | - 150,000.00 төгрөг |
| 4 тн шахдаг авто машин        | - Ахуйн хог хаягдал    | - 85,000.00 төгрөг  |
| 4 тн задгай тэвштэй автомашин | - Ахуйн хог хаягдал    | - 85,000.00 төгрөг  |
| 4 тн задгай тэвштэй автомашин | - Барилгын хог хаягдал | - 95,000.00 төгрөг  |
- 4.4 “Хог хаягдлын тухай” хууль, бусад эрх зүйн актын өөрчлөлт болон зах зээлийн үнийн интервалаас хамаарч үйлчилгээний үнийн тарифт өөрчлөлт оруулж болно.
- 4.5 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд төлбөрийг төлсний дараа гүйцэтгэгч тээвэрлэнэ.
- 4.6 Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан хог хаягдлын тээвэрлэлтийг өвөл, зуны батлагдсан графикийн дагуу төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.
- 4.7 Хог тээвэрлэлтийн төлбөрийг ААН, албан байгууллага, үйлчилгээний газрууд нь гэрээний 3.3-д заасан хугацаанд бүрэн төлж барагдуулна. Төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хоног тутам 0,5%-ийн алданги төлнө.

#### Тав. Хамтран хүлээх хариуцлага

- 5.1 Талууд энэхүү гэрээ зөрчигдөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.
- 5.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
- 5.3 Нийслэл дүүргээс зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдан ажиллах үед хог ачилтын хуваарь 1 өдрөөр хойш шилжих асуудал гарч болно. Үүнийг тухайн ААН, байгууллагад урьдчилан мэдэгдэх бөгөөд төлбөр төлөлтөнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй.

#### Зургаа. Торгуулиас чөлөөлөгдөх нөхцөл

- 6.1 Байгаль, цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, хүндэтгэх шалтгаанаар авто зам хаагдсаны улмаас хог ачих боломжгүй болсон.
- 6.2 Удирдах, дээд байгууллагын шийдвэрээр автомашиныг өөр ажилд дайчилсан тохиолдолд энэхүү гэрээний 5.2 дахь заалт хамаарахгүй.

#### Долоо. Бусад

- 7.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

#### Найм. Нэмэлт өөрчлөлт

20 ..... оны ..... сарын ..... –ний өдөр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав.

.....  
.....  
.....

002213

Зураг 22. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ

### Ес. Гэрээний сунгалт

9.1 Гэрээний хугацаа дуусаж, талууд гэрээг цуцлах талаар албан бичгээр санал гаргаагүй бол гэрээг анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

9.1.1 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Тайлбар: \_\_\_\_\_

9.1.2 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: \_\_\_\_\_


Гэрээ сунгасан: \_\_\_\_\_

Тайлбар: \_\_\_\_\_

### Арав. Гэрээ байгуулсан талууд

#### ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛ:

ХУД-ИЙН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ  
ОНӨААТҮГ-ЫН ХОРОО ХАРИУЦСАН  
ХЯНАЛТЫН АХЛАХ АЖИЛТАН


.......... Б.БАТЦЭЦЭГ

Утас: 98111776

Тээвэрлэлтийн захиалга өгөх, санал гомдлын  
утас: 95071965

#### ЗАХИАЛАГЧ ТАЛ:

БИ СИ ЭМ ЭМ ХХК-ИЙН  
МЕНЕЖЕР

.......... Б.АЗЖАРГАЛ

Утас: 89062538, 99232436

Хаяг: ХУД, 21-р хороо, Үнэсгэний хөндий  
/БГД-ийн 5 хороо, 107 тоот/

*Зураг 23. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ*

## ЕС.ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

ОХШХ-ийн хүрээнд уурхай болон бутлан ангилах үйлдвэр, ажилчдын тосгон орчмоос агаарын чанарын болон хөрсний бохирдлын дээжийг жил бүр авч шинжлүүлж байна.



**MNAS**  
Accreditation  
system  
TL 08  
MNS ISO/IEC

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: bohzt@gmail.com

**СОРИЛТЫН ДҮН**



**БАЙГАЛЬ**  
ОРЧИН ХЭМЖИЛЭЛТИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

Дугаар он/№	: 2022/A-312
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Би Си Эм Эм” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхишиг агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл	: 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2022.10.15
Дээжийн тодорхойлолт	: ХУД 13-р хороо дарганы үйлдвэр
Шинжилгээний аргын стандарт	: MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021 CA3 A07-2016
Шинжилсэн огноо	: 2022.10.21
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн :	

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл мг/м <sup>3</sup>	Нийт Тоос /TSP/ мг/м <sup>3</sup>	Дуу чимээ /ДБА/
1	Ажилчдын кемп	X/15	07:35	0.015	0.022	0.085	45
2	Үйлдвэрийн орчим	X/15	08:30	0.018	0.026	0.087	75
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:  
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан:  
Агаарын хэсгийн инженер



Э.Оюунтуяа

Д.Түмэндэлгэр

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Зураг 24. Агаарын чанар, дуу чимээний шинжилгээний хариу



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/ № : 2022/ 678-679  
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Би Си Эм Эм” ХХК  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхишиг, агаарын хэсгийн техникч  
 Дээжийн тоо, төрөл : 2, хөрсний сорьц  
 Хүлээн авсан огноо : 2022.10.17  
 Дээжийн тодорхойлолт : Улаанбаатар хот – Хан-Уул дүүрэг, 13-р хороо  
 Дайрганы үйлдвэр  
 Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022  
 Шинжилсэн огноо : 2022.10.20  
 Хуудасны тоо : 1/1  
 Үр дүн:

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Кобальт (Co)	Стронци (Sr)
1	Үйлдвэр орчим	<0.005	15.1	<0.005	<0.005	94.3	28.8	15.7	284.6
2	Ажилчдын кемп	0.1	21.8	<0.005	<0.005	99.6	29.5	25.1	349.5
	<b>MNS 5850:2019 / ЗДХ/</b>	<b>3</b>	<b>100</b>	<b>2</b>	<b>150</b>	<b>300</b>	<b>100</b>	<b>50</b>	<b>800</b>

Шинжилгээ гүйцэтгэсэн ИТГЭМЖЛЭЛИЙН  
Хөрсний хэсгийн инженер Д.Баярхулан  
 Хянаж баталгаажуулсан ИТГЭМЖЛЭГДСЭН  
Хөрсний хэсгийн инженер Б.Даваасүрэн  
 ЛАБОРАТОРИ  
 УИТ0235

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй

Зураг 25. Хөрсний шинжилгээний хариу



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: bohzt1@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2022/ Ц-190  
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Би Си Эм Эм" ХХК  
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхишиг, БОХЗТЛ  
Сорьцын тоо, төрөл : 1, ус  
Сорьцыг авсан огноо : 2022.10.15  
Сорьцын тодорхойлолт : Усны сорьц  
Шинжилгээний аргын стандарт : **MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999,  
MNS 6271:2011, MNS 4424:2005, MNS 1097:1970**  
Шинжилсэн огноо : 2022.10.16-10.25  
Хуудасны тоо : 2 /2  
Үр дүн : 1

Сорьцын нэр	pH	EC µS/cm	SO <sub>4</sub> мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO <sub>3</sub> мг/л	Эрд мг/л	Хат мг-экв/л
ХУД, 13-р хороо Худгийн ус	7.53	458	46.1	26.3	77.1	11.8	3.5	199	364	4.82
<b>MNS 0900:2018</b>	<b>6.5-8.5</b>	<b>1000</b>	<b>500</b>	<b>350</b>	<b>100</b>	<b>30</b>	-	-	-	<b>7.0</b>

Тайлбар: EC - цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэсжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Г.Нарансолонго

Хянаж баталгаажуулсан инженер:

Ц.Мийдүв



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг 26. Усны шинжилгээний харуу



## **АРАВ. УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний дагуу 2022 оны уулын ажлын төлөвлөгөө, БОМТ-г боловсруулсан батлуулсан ба үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан болно. Түүнчлэн ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.

## **АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан БОАЖЯ-ны цахим системд илгээсэн ба НБОГ-т хэвлэн бэлтгэж, танилцуулахаар хүргүүлсэн болно.

### **ДҮГНЭЛТ**

Манай компани нь 2022 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Тоосжилт ихтэй үед зам усалгааг тогтмол хийж байсан.
- ✓ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд НБОГ-тай хамтран ажилласан. Уг ажлын зардалд 1.0 сая төгрөг зарцуулсан болно.
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж байсан. Түүнчлэн хог хаягдлыг түр хадгалах цэгийг байгуулсан.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанар, дуу чимээний хэмжилт хийлгэж, хөрсний шинжилгээ авч лабораторид шинжлүүлсэн.
- ✓ Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ, ус ашиглах гэрчилгээ зэргийг холбогдох газруудаас гаргуулсан.
- ✓ Өрөмдлөг тэсэлгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бөгөөд тэсрэх бодисын сав баглаа боодлыг гэрээт байгууллагад буцаан өгч аюул осолгүй ажилласан.

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хийгдэх ёстой ажлуудыг цаг тухайд нь 100 хувь хийж гүйцэтгэсэн болно.